

2026 он 02 сар 09 өдөр

№ 26/01

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хөрөнгө шилжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

Компанийн 2023 оны 11 сарын 9-ний өдрийн 23/32 тоот тогтоолоор Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлэх ажлын хүрээнд Даац инвестмент ХХК-ийн 50.9 хувийн хувьцааг өртгөөр нь шилжүүлэх ажил хийгдээгүй болохыг **ТЭМДЭГЛЭН**,

1. Компанийн 2023 оны 11 сарын 9-ний өдрийн 23/32 тоот тогтоолын 1-р заалтын Даац инвестмент ХХК-тай холбоотой хэсгийг хүчингүй **БОЛГОСУГАЙ**.
2. Компанийн 2023 оны 11 сарын 9-ний өдрийн 23/32 тоот тогтоолын хүрээнд Хөвсгөл ХК-ийн 100 хувийн охин компани Иксгрууп ХХК-д Даац инвестмент ХХК-ийн 50.9 хувийн хувьцааг өртгөөр нь шилжүүлэхийг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ**.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Иксгрууп ХХК-тай холбогдох гэрээ хэлцэл байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2026 он 02 сар 09 өдөр

№ 26/02

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан Зээлийн гэрээнд үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор Ард Актив ХЗХ болон Компани хооронд байгуулсан батлан даалтын гэрээний хугацаанд өөрчлөлт оруулахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ**.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулан компанийг төлөөлж холбогдох баримт бичиг, батлан даалтын гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүнд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудит эрхэлсэн захирал М.Мөнх-Эрдэнэд тус тус **ОЛГОСУГАЙ**.
3. Сонирхлын зөрчилгүй буюу хараат бус гишүүд шийдвэр гаргасан болохыг **ДУРДСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 2 сарын 9-ны өдрийн
26/02 тоот тогтоолын хавсралт 1

Доорх таван зээлийн гэрээний хугацаа сунгагдаж байгаатай холбоотой Компани батлан даалтын гэрээг 1 жилээр сунгаж, баталгаажуулах:

Зээлдэгчийн нэр	Бүт.нэр	Олгосон	Дуусах	Олгосон дүн	Зээлийн үлдэгдэл	Хүү
АРД СУППОРТ ХХК	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2023.12.25	2025.12.25	2,500,000,000.0 0	2,500,000,000.0 0	22
АРД ФИНТЕК СОЛЮШН	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2023.12.25	2025.12.25	2,500,000,000.0 0	2,500,000,000.0 0	22
ТЭНГЭР СИСТЕМС ХХК	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2023.12.25	2025.12.25	2,500,000,000.0 0	2,500,000,000.0 0	22
АКЕЛА СЕКЬЮРИТИ	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2023.12.26	2025.12.26	2,500,000,000.0 0	2,500,000,000.0 0	22
МОНГОЛИАН НЭЙШНЛ ЭКВИТИ ТРАСТ	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2023.12.27	2025.12.27	2,500,000,000.0 0	2,500,000,000.0 0	22